



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/149

Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Засаг даргын 2017 оны А/240 тоот захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвөөс санхүүжигдэх "Цагаандэлгэр сумын цэцэрлэгийн барилгын дээврийн засварын ажил"-ын гүйцэтгэгчээр "Үлэмж инвест" ХХК-ийг сонгон 80 637 553 /наян сая зургаан зуун гучин долоон мянга таван зуун тавин гурван/ төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Үлэмж инвест" ХХК –ний захиралд үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Н.Эрдэнэ-Очир/, Цагаандэлгэр сумын Засаг дарга /Д.Буджав/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

0300450